



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/16/04

Номгон

Г Судалгааны ажлыг шуурхай зохион
байгуулахад дэмжлэг үзүүлэх ажлын
хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн "Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааг зохион байгуулах тухай" А/88 дугаар тушаал, Үндэсний Статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн "Аргачлал шинэчлэн батлах тухай" А/16-А/04 дүгээр хамтарсан тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд "Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох хосолмол аргачлал"-аар нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн мэдээллийг шинэчлэх, мэдээлэл цуглуулах ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангах, нэгдсэн чиглэл өгч, зөвлөн туслах, дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Батсуурь (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд:

В.Наранчимэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Ж.Алтангэрэл (Аймгийн Онцгой байдлын газрын дарга)

Б.Мөнхбаяр (Аймгийн Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн дэд хурандаа)

Б.Ганчимэг (Статистикийн хэлтсийн дарга)

Ц.Мөнхжаргал (Улсын бүртгэлийн хэлтсийн дарга)

С.Амармөнх (Авто тээврийн төвийн дарга)

645210861

2.

Г.Энхбаяр (Баянхонгор сумын Засаг дарга)
(Сумдын Засаг дарга нар)

Нарийн бичгийн дарга


Л.Мөнхцацрал (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Нийгмийн
халамжийн хэлтсийн дарга)

2.Орон нутагт мэдээлэл цуглуулах тоологчдод газарчлах, судалгаанд хамруулах өрхүүдэд саадгүй очих ажлыг шуурхай зохион байгуулж, багийн Засаг дарга нарыг үүрэгжүүлж ажиллуулахыг сумдын Засаг дарга нарт, судалгааны багийн ажилтнуудыг гэмт халдлагад өртөх, гэмтэж бэртэх эрсдэлээс сэргийлэх чиглэлийг сумын Хэсгийн цагдаа, эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудад өгч ажиллахыг Б.Мөнхбаяр (Аймгийн Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн дэд хурандаа), сумдын Эрүүл мэндийн төвийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Мэдээлэл цуглуулах ажлыг зохион байгуулах нэгдсэн төлөвлөгөө батлуулан, төрийн байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан хаагчид, гэрээт ажилтан, тоологч, хөтөч нарт чиглэсэн сургалтыг хариуцлагатай зохион байгуулж ажиллахыг Ажлын хэсэгт үүрэг болгосугай.

4.Судалгааны ажлыг шуурхай зохион байгуулахад нэгдсэн удирдлага арга зүйгээр ханган, байнгын ажиллагаатай ажиллаж, захирамжийн хэрэгжилтийг хангахыг Ажлын хэсгийн ахлагч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА



Д. МӨНХСАЙХАН